



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар A/489

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар 32.7 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийн 4.2.3, 4.3.2.1 дэх заалт, 2019 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан "150 мянган айл-Орон сууц хөтөлбөр"-ийн 4.4.3.7 дахь заалт, аймгийн нийгэм, эдийн засгийн 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 дугаар бүлгийн 3.1.1, 3.1.2 дахь заалт, Үнэлгээний хорооны 2020 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 111 дүгээр зөвлөмж, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 21 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Солонго хороололд баригдах 50 айлын 2 блок орон сууцны барилга угсралтын ажлыг хувийн хөрөнгө оруулалтаар барихаар төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж, гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг "Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ын захирал (Б.Дэлгэр)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, дунг тайлагнаж ажиллахыг "Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ын захирал (Б.Дэлгэр), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (М.Уган-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ), Мэргэжлийн хяналтын газар (Г.Гантулга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

